



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СБА-2023/38/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баруун-Урт сум 2023 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: М.Нарантуяа Утас: 70518396 Аудитын менежер: Г.Даваа Утас: 70512123 Аудитор: Б.Мөнхбамбар Утас: 70512127</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	3
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	5
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	14
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	15
<b>4.1 Ерөнхий зүйл</b> .....	15
<b>4.2 Материаллаг байдал</b> .....	15
<b>4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт</b> .....	16
<b>4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b>	16
<b>4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт</b> .....	16
<b>4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт</b> .....	16
<b>4.5.1 Завсрын аудитын талаар</b> .....	16
<b>5.1 Төлбөрийн акт</b> .....	17
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	17

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас: 70518396, Факс: 70518396  
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2023.02.24 № 75

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

СҮХБААТАР АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР  
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА Ж.АВАА ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

### Аудитын гол асуудал

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газар нь төрийн албан хаагчдын цалингийн нэгдсэн системд бүрэн нэвтэрч, төрийн сангийн ажил гүйлгээг цахим болох бэлтгэл ажлын ханган ажиллаж байна.

### Бусад асуудлын хэсэг

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2022 гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 4 зорилт, 96 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр 90.3 хувийн биелэлттэй хэрэгжүүлсэн байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

D:/Bichig hereg/2023/A4 toot

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>70,642,587.80</u></b>	<b><u>77,363,680.25</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	1,339,358.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	-	1,339,358.00
3351	Байгууллагаас авах авлага	-	1,339,358.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	70,642,587.80	76,024,322.25
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	68,712,587.80	52,964,322.25
35410	Бичиг хэргийн материал	645,000.00	645,000.00
35420	Аж ахуйн материал	66,421,689.00	51,399,322.25
35440	Түлш, шатах тослох материал	725,898.80	-
35470	Бусад хангамжийн материал	920,000.00	920,000.00
35600	Мал амьтад	1,930,000.00	23,060,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,362,178,970.46</u></b>	<b><u>2,098,667,076.57</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,362,178,970.46	2,098,667,076.57
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,340,579,370.46	2,048,307,176.57
39201	Барилга, байгууламж, орон сууц	523,999,864.20	543,999,864.20
39202	Хуримтлагдсан элэгдэл	(47,941,237.56)	(65,334,800.77)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	347,525,869.00	396,925,869.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(147,271,537.94)	(180,298,211.78)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	98,240,698.46	105,302,600.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(47,327,736.65)	(43,087,464.38)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	53,985,296.77	51,099,600.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(29,078,724.77)	(22,372,270.64)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,114,439,431.00	1,860,894,205.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(525,992,552.05)	(598,822,214.06)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	21,599,600.00	50,359,900.00
39301	Програм хангамж	432,100.00	2,427,100.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(432,100.00)	(698,100.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	21,869,000.00	49,035,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(269,400.00)	(404,100.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,432,821,558.26</u></b>	<b><u>2,176,030,756.82</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>740,670.30</u></b>	<b>=</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	740,670.30	-
<b>413</b>	<b>Өглөг</b>	740,670.30	-
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	740,670.30	-
41361	Байгууллагад төлөх өглөг	738,670.30	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	2,000.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,432,080,887.96</u></b>	<b><u>2,176,030,756.82</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,432,080,887.96	2,176,030,756.82
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	208,397,879.23	208,397,879.23

51101	Өмч: - төрийн	208,397,879.23	208,397,879.23
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,000,171,376.39</b>	<b>1,744,121,245.25</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,000,171,376.39	1,000,171,376.39
51220	Тайлант үеийн үр дүн	-	743,949,868.86
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	223,511,632.34	223,511,632.34
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,432,821,558.26</u></b>	<b><u>2,176,030,756.82</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,026,904,935.50</b>	<b>1,853,187,583.50</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>312,771,213.00</b>	<b>794,251,633.25</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	312,771,213.00	794,251,633.25
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	312,771,213.00	794,251,633.25
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,025,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	299,746,213.00	794,251,633.25
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>714,133,722.50</b>	<b>1,058,935,950.25</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	202,061,322.50	110,453,750.25
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,000,000.00	35,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	72,698,280.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	91,938,542.50	2,201,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	36,424,500.00	73,252,150.25
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	512,072,400.00	948,482,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	512,072,400.00	948,482,200.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>828,154,050.36</b>	<b>1,109,237,714.64</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>828,154,050.36</b>	<b>1,109,237,714.64</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	763,738,030.69	986,830,141.42
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	283,027,700.50	296,002,652.25
210101	Үндсэн цалин	198,102,703.00	224,488,714.39
210102	Нэмэгдэл	53,760,187.00	51,109,776.24
210104	Урамшуулал	6,996,087.50	20,404,161.62
210105	Гэрээт ажлын хөлс	24,168,723.00	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	34,673,864.00	37,381,358.15
210201	Тэтгэврийн даатгал	23,515,612.00	25,492,264.49
210202	Тэтгэмжийн даатгал	2,745,840.00	2,999,618.41
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,196,672.00	2,399,894.50
210204	Ажилгүйдлийн даатгал	548,068.00	584,043.84

210205	Эрүүл мэндийн даатгал	5,667,672.00	5,905,536.91
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	18,000,199.83	19,737,538.43
210301	Гэрэл, цахилгаан	11,585,847.53	12,041,931.63
210302	Түлш, халаалт	5,814,352.30	7,095,606.80
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	600,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	32,301,635.00	48,504,695.00
210401	Бичиг хэрэг	3,369,670.00	4,322,420.00
210402	Тээвэр, шатахуун	26,099,575.00	35,072,365.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,456,390.00	2,854,610.00
210404	Ном, хэвлэл	-	2,500,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	575,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	376,000.00	3,180,300.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	600,000.00	600,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.00	600,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	23,912,000.00	7,297,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,250,000.00	599,600.00
210604	Урсгал засвар	5,662,000.00	6,698,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,722,000.00	11,769,000.00
210702	Дотоод албан томилолт	1,722,000.00	11,769,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	29,622,796.00	71,246,254.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,123,153.00	69,178,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	168,575.00	464,833.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3,500.00	478,420.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	89,400.00
210807	Газрын төлбөр	253,268.00	535,001.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	30,300.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	500,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	339,877,835.36	494,291,043.59
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	223,976,902.00	346,629,575.70
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,246,980.00	4,133,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	114,653,953.36	143,527,667.89
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	64,416,019.67	122,407,573.22
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	29,083,503.00	28,467,400.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	6,158,603.00	6,284,400.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	19,223,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,124,900.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,800,000.00	2,960,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	35,332,516.67	93,940,173.22
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,332,516.67	93,940,173.22
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>198,750,885.14</b>	<b>743,949,868.86</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>733,897,765.50</u></b>	<b><u>1,058,935,950.25</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>13,025,000.00</b>	-
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	13,025,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13,025,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,025,000.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b><u>720,872,765.50</u></b>	<b><u>1,058,935,950.25</u></b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	208,800,365.50	110,453,750.25
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,000,000.00	35,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	72,698,280.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	91,938,542.50	2,201,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	43,163,543.00	73,252,150.25
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	512,072,400.00	948,482,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	512,072,400.00	948,482,200.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>725,178,165.50</u></b>	<b><u>935,892,176.25</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b><u>725,178,165.50</u></b>	<b><u>935,892,176.25</u></b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b><u>660,762,145.83</u></b>	<b><u>813,335,643.03</u></b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	283,027,700.50	296,497,010.25
210101	Үндсэн цалин	198,102,703.00	223,324,905.39
210102	Нэмэгдэл	53,760,187.00	52,767,943.24
210104	Урамшуулал	6,996,087.50	20,404,161.62
210105	Гэрээт ажлын хөлс	24,168,723.00	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	34,673,864.00	37,381,358.15
210201	Тэтгэврийн даатгал	23,515,612.00	25,492,264.49
210202	Тэтгэмжийн даатгал	2,745,840.00	2,999,618.41
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,196,672.00	2,399,894.50
210204	Ажилгүйдлийн даатгал	548,068.00	584,043.84
210205	Эрүүл мэндийн даатгал	5,667,672.00	5,905,536.91
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	18,726,098.33	19,011,639.63
210301	Гэрэл, цахилгаан	11,585,847.53	12,041,931.63
210302	Түлш, халаалт	6,540,250.80	6,369,708.00
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	600,000.00

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	34,532,965.00	47,405,800.00
210401	Бичиг хэрэг	3,369,670.00	4,040,420.00
210402	Тээвэр, шатахуун	28,220,905.00	35,660,770.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,566,390.00	2,854,610.00
210404	Ном, хэвлэл	-	2,500,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	575,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	376,000.00	1,775,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	600,000.00	600,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.00	600,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	25,512,000.00	8,122,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,000,000.00	599,600.00
210604	Урсгал засвар	7,512,000.00	7,523,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,722,000.00	11,771,000.00
210702	Дотоод албан томилолт	1,722,000.00	11,771,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	34,407,636.00	76,801,254.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	33,907,993.00	74,726,100.00
210803	Даатгалын үйлчилгээ	168,575.00	464,833.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3,500.00	485,920.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	89,400.00
210807	Газрын төлбөр	253,268.00	535,001.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	30,300.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	500,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	227,559,882.00	315,744,981.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	226,099,902.00	311,329,181.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,459,980.00	4,415,800.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>64,416,019.67</b>	<b>122,556,533.22</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	29,083,503.00	28,616,360.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	6,158,603.00	6,433,360.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	19,223,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,124,900.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,800,000.00	2,960,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	93,940,173.22
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	93,940,173.22
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	35,332,516.67	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,332,516.67	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>8,719,600.00</u></b>	<b><u>123,043,774.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>8,719,600.00</b>	<b>123,043,774.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>8,719,600.00</b>	<b>123,043,774.00</b>

<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	8,719,600.00	123,043,774.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,719,600.00	123,043,774.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(8,719,600.00)</u></b>	<b><u>(123,043,774.00)</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	0.00	-

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	208,397,879.23	223,511,632.34	801,420,491.25	-	1,233,330,002.82
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>208,397,879.23</b>	<b>223,511,632.34</b>	<b>801,420,491.25</b>	-	1,233,330,002.82
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайланг үеийн үр дүн	-	-	198,750,885.14	-	198,750,885.14
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	208,397,879.23	223,511,632.34	1,000,171,376.39	-	1,432,080,887.96
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	208,397,879.23	223,511,632.34	1,000,171,376.39	-	1,432,080,887.96
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>208,397,879.23</b>	<b>223,511,632.34</b>	<b>1,000,171,376.39</b>	-	1,432,080,887.96
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайланг үеийн үр дүн	-	-	743,949,868.86	-	743,949,868.86
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>208,397,879.23</b>	<b>223,511,632.34</b>	<b>1,744,121,245.25</b>	-	2,176,030,756.82

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	948482200.00	876903478.03
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	948482200.00	876903478.03
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	917690100.00	848287118.03
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	309645300.00	294319010.25
210101	Үндсэн цалин	233079100.00	223324905.39
210102	Нэмэгдэл	61872200.00	52767943.24
210104	Урамшуулал	14694000.00	18226161.62
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	38705600.00	37381358.15
210201	Тэтгэврийн даатгал	26319800.00	25492264.49
210202	Тэтгэмжийн даатгал	3096400.00	2999618.41
210203	ҮОМШӨ-ний даатгал	2477200.00	2399894.50
210204	Ажилгүйдлийн даатгал	619300.00	584043.84
210205	Эрүүл мэндийн даатгал	6192900.00	5905536.91
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	23550000.00	18619735.63
210301	Гэрэл, цахилгаан	12700000.00	11650027.63
210302	Түлш, халаалт	10250000.00	6369708.00
210303	Цэвэр, бохир ус	600000.00	600000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	38692000.00	37453705.00
210401	Бичиг хэрэг	4500000.00	4040420.00

210402	Тээвэр, шатахуун	25822000.00	25788675.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,520,000.00	2,774,610.00
210404	Ном, хэвлэл	2,500,000.00	2,500,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	575,000.00	575,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,775,000.00	1,775,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	600,000.00	600,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.00	600,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	18,600,000.00	18,122,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,600,000.00	5,599,600.00
210602	Тавилга	-	5,000,000.00
210604	Урсгал засвар	8,000,000.00	7,523,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	13,916,000.00	11,771,000.00
210702	Дотоод албан томилолт	13,916,000.00	11,771,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	37,571,000.00	25,429,154.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	32,500,000.00	21,359,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	225,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	765,000.00	464,833.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	500,000.00	485,920.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	150,000.00	89,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,391,000.00	1,995,000.00
210807	Газрын төлбөр	540,000.00	535,001.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	500,000.00	500,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	436,410,200.00	404,590,555.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	430,610,200.00	400,174,755.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,800,000.00	4,415,800.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	30,792,100.00	28,616,360.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	30,792,100.00	28,616,360.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	6,433,400.00	6,433,360.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	21,358,700.00	19,223,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00	2,960,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	948,482,200.00	876,903,478.03
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	948,482,200.00	876,903,478.03
132001	Орон нутгийн төсвөөс	948,482,200.00	876,903,478.03
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	28.00	28.00
620001	Удирдах ажилтан	9.00	9.00
620002	Гүйцэтгэх ажилтан	8.00	8.00
620003	Үйлчлэх ажилтан	11.00	11.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>88,092,299.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>88,092,299.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	88,092,299.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	-	2,178,000.00
210104	Урамшуулал	-	2,178,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	-	391,904.00
210301	Гэрэл, цахилгаан	-	391,904.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	9,952,095.00
210402	Тээвэр, шатахуун	-	9,872,095.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	80,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	53,367,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	53,367,100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	22,203,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	22,203,200.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	88,092,299.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	88,092,299.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	29,445,182.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,201,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	56,445,517.00

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газар “Сум орон нутгийн хөгжил дэвшлийг хангаж нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох, төрийн бодлого шийдвэр, хууль тогтоомжийг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээг иргэн бүрд ил тод, жигд хүртээмжтэй хүргэх” эрхэм зорилгын хүрээнд сумын нийгэм эдийн засгийн чадавхыг дээшлүүлэхэд чиглэсэн оновчтой бодлого, нийгмийн салбарын хөгжлийг ахиулахад дэмжлэг үзүүлэх зорилго, үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 743,209.1 мянган төгрөгөөр буюу 52 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>Б</b>	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	1,339.4	1,339.4
Бараа материал	70,642.6	76,024.3	5,381.7
Үндсэн хөрөнгө	1,362,179.0	2,098,667.0	736,488.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,432,821.6</b>	<b>2,176,030.7</b>	<b>743,209.1</b>
Өр төлбөр	740.7	-	(740.7)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,432,080.9	2,176,030.7	743,949.8
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,432,821.6</b>	<b>2,148,958.0</b>	<b>743,209.1</b>

- Авлагын данс 1,339.4 мянган төгрөгөөр өссөн нь жилийн эцэст 1 гүйлгээ давхар хийгдсэнээс болж өссөн байна.
- Үндсэн хөрөнгө данс 2,098,667.0 мянган төгрөг болж 736,488.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгө 123,043.8 мянга, үнэ төлбөргүй 729,806.0 мянга нийт 852,849.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, 30,823.8 мянган төгрөг хөрөнгийг акталж, хөрөнгийн элэгдлээр буурсан нөлөөлсөн байна.
- Засгийн газрын хувь оролцоо данс 743,949.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүн нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,088,890.1 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс орон төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 948,482.2 мянга төгрөг батлагдсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхэд орон нутгийн төсвөөс 948,482.2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 876,903.6 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулжээ.

Гүйцэтгэлээр орон нутгаас 948,482.2 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 71,578.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 876,903.6 мянган төгрөг буюу 92.4 хувьтай зарцуулсан байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	/мянган төгрөгөөр/		
			Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101-Үндсэн үйл ажиллагаа	312,591.4	297,582.7	15,008.7	95%
2	80103-Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	65,060.6	60,737.6	4,323.0	93%
3	80106-Баг, хорооны үйл ажиллагааны зардал	94,318.7	86,118.9	8,199.8	91%
4	80714-Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт	6,433.4	6,433.4	0.0	100%
5	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	22,223.0	22,183.0	40.0	100%
6	81102-Орон нутгийн нөөц хөрөнгө	63,000.0	59,964.7	3,035.3	95%
7	81518-Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зардал	263,895.8	254,405.8	9,490.0	96%
8	81701-Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	88,823.6	68,765.1	20,058.5	77%
9	81549-Ахмадын сан	2,135.7	1,648.4	487.3	77%
10	82706-Гоц халдварт өвчний голомтын буруулах, тархалтыг багасгах	30,000.0	19,064.0	10,936.0	64%
НИЙТ		948,482.2	876,903.6	71,578.6	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 35,000.0 мянга, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 2,201.6 мянга, Төсвийн

байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 73,252.2 мянга, нийт 110,453.7 мянган төгрөгийн орлого төвлөрч гүйцэтгэлээр 88,092.3 мянган төгрөгийг зарцуулж 22,361.4 мянган төгрөгийг дээд шатны төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулалтыг авч үзвэл цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 2,178.0 мянга, гэрэл, цахилгааны зардалд 391.9 мянга, тээвэр, шатахуун зардалд 9,872.1 мянга, шуудан, холбоо, интернэтийн төлбөрт 80.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 53,367.1 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 22,203.2 мянга нийт 88,092.3 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Мөнхбамбар, гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 1,109,144.0 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 22,182.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1<sup>1</sup>, 15.2.3<sup>2</sup>-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад байр ашиглалттай холбоотой тогтмол зардлууд 1,737.3 мянга, бичиг хэрэг, тээвэр шатахууны зардал 9,371.0 мянга нийт 11,108.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Дээрх зардал өмнөх оноос нэмэгдсэн учир шалтгааныг авч үзвэл:

- *Тээвэр шатахуун, бичиг хэргийн зардал: Шатах тослох материал, бичиг хэргийн материалын үнэ өмнөх оноос дунжаар 52.0 хувиар нэмэгдсэн нь гол нөлөөлөл үзүүлсэн байна.*

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторовын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тайлант онд гарсан өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гаргасан тушаал шийдвэр, орлого зарлагын мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулсан байна.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газард завсрын аудит хийгээгүй.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

*Хүснэгт 3 Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/				
	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	-	1	-	100
Зөвлөмж	1	-	1	-	100
Нийт дүн	2	-	2	-	100

<sup>1</sup> байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

<sup>2</sup> сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томиллолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,878.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч<sup>3</sup> төлбөрийн акт тогтоов.

### 5.1 Төлбөрийн акт

Сумын орлогч даргад нууцын нэмэгдлийг тушаал шийдвэргүйгээр 1,110.4 мянга, албан хаагчдад илүү цагийн хөлс 767.6 мянга нийт 1,878.0 төгрөгийг илүү олгож, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн 6.4.1 / Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;/, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн 41.2.3 /төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;/ Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.1 /улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, докторын зэргийн нэмэгдлээс;/, Засгийн газрын 2018 оны 283 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтыг тус тус зөрчсөнд төлбөрийн акт тогтоолоо.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/												
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалин хөлс илүү тооцож олгосон	1	1,878.0	1	1,878.0	-	-	-	-	-	-	-	-
Дүн	1	1,878.0	1	1,878.0	-	-	-	-	-	-	-	-

<sup>3</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.